



СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Н. ТҮВШИНЖАРГАЛД

ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

48000 Сайвцагаан сум, Дундговь аймаг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08,
Факс: 70-59-24-39

2014.02.24 № 141

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Статистикийн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, (цэвэр хөрөнгө) өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл, тодруулгад аудит хийв. Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл

Статистикийн хэлтсийн удирдлага 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн арга аргачлал, заавар журам", Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитын төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

100003004

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Статистикийн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон (цэвэр хөрөнгө) өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.



ЕРӨНХИЙ АУДИТОР

Б.ДОЛГОРСҮРЭН